



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/132

Шивээговь сум

Орон сууцны 3, 6, 7, 8 дугаар байрны
орцны хаалга шинэчлэх ажлын гүйцэтгэлийг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 271 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “ Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны орны хаалга шинэчлэх ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


- Комиссын дарга: Ч.Сугармаа (сумын Засаг даргын орлогч)
- Нарийн бичгийн дарга: Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
- Гишүүд: Б.Дэлгэрдалай (аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Н.Амаржаргал (1-р багийн Засаг дарга)

Д.Эрдэнэ ("Тохилог сууц" сууц
өмчлөгчдийн холбооны дарга)

2. Орон сууцны 3,6,7,8 дугаар байрны орцны хаалга шинэчлэн сольж суулгасан тул сууц өмчлөгчдийн холбооны хөрөнгөнд бүртэгж, ашиглалт хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Сууц өмчлөгчдийн холбооны дарга (Д.Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан ажлын гүйцэтгэлд хүлээн авсан акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ